



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/75

Баян-Өндөр сум

Тусгай зөвшөөрөл сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 19.17, 19.18, 19.20, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1, 5.3 дугаар зүйлийн 1, 5.5 дугаар зүйлийн 10, 6.1 дугаар зүйлийн 1.3, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны "Журам шинэчлэн батлах, тушаалд өөрчлөлт оруулах тухай" А/383 тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын 2024 оны 10 дугаар сарын 02-ний өдрийн 09 дүгээр хурлын шийдвэрийн дагуу сунгалт хийх байгууллагуудыг нэгдүгээр, түдгэлзүүлэх байгууллагыг хоёрдугаар, хүчингүй болгох байгууллагыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн газарт сар бүрийн мэдээ тайланг хугацаанд нь ирүүлж, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, стандартуудыг хэрэгжүүлэн ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д даалгасугай.

ДАРГА




Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны
10 дүгээр сарын 13 ны өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг, байршил	Хугацаа
1	Цамбагарав хайрханы хишиг ХХК-ын "Алтангагнуур" клиник	Уламжлалтын тусламж үйлчилгээ	Согоот баг 5 дугаар байрны 41б	3 жил



ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг, байршил	Түдгэлзүүлэх хугацаа
1	Бүтээлч булаг ХХК –ын "Домч. булаг" 2-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Цагаанчулуут баг, Зэс апартамент 1 тоот	2024 оны 10-р сарын 02-ноос 2025 оны 01-р сарын 02 хүртэл 3 сар
2	Уран тана ХХК-ын "Е-Нарру-1" клиник	Нүүр ам судлалын тусламж үйлчилгээ	Зэст баг, 1-3-26	2024 оны 10-р сарын 02-ноос 2025 оны 01-р сарын 02 хүртэл 3 сар
3	Хос Өлзий баяр ХХК-ын "Хос Өлзийн" клиник	Сувилахуйн тусламж үйлчилгээ	Хүрэнбулаг баг 4-р хороолол 24-р байр 3 тоот	2024 оны 10-р сарын 02-ноос 2025 оны 01-р сарын 02 хүртэл 3 сар
4	Дөт кредит ХХК-ын "Е-Аптек" 2-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Уурхайчин-1 хорооллын 6-1 дүгээр байр	2024 оны 10-р сарын 02-ноос 11-р сарын 02 хүртэл 1 сар
5	Түгээмж ХХК-ын "Цээнэ" 2-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Баянбулаг баг, "Rose town" орон сууц, 10-р хорооллын 1-р байр В1 давхар 5 тоот	2024 оны 10-р сарын 02-ноос 11-р сарын 02 хүртэл 1 сар

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны
10 дүгээр сарын 21-ны өдрийн
А/Х дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦУЦЛАХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил
1	Фарида ном ХХК-ын	Ган фарм эмийн сан 2-р зэрэглэлийн эмийн сан	Цагаан чулуут баг 7 а хороолол 11-р байр 101 тоот